


БАТЛАВ

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР БӨГӨӨД
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА

..... /Б.УУГАНБАЯР/



НАЛАЙХ ДҮҮРГИЙН 1 ДҮГЭЭР ХОРООНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН
ТӨСЛИЙН ЦАХИЛГААН ХАНГАМЖИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ АЖЛЫН ЗУРАГ
ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР


2020 оны 4-р сарын 24-ний өдөр

Дугаар: ГБМЗХ 2020/17-78


Улаанбаатар хот

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none">- Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага;- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 28/14 дүгээр тогтоолоор баталсан “Налайх дүүргийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө”- Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 07 дугаар сарын 09-ны өдрийн 118 дугаар тогтоол- Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр;- Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл;- Нийслэлийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/398 дугаар захирамж;- Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 02/271 дүгээр албан бичиг;- 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Газар, барилгажилтын мэргэжлийн зөвлөлийн 17 дугаар хурлын шийдвэр;- Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2020 оны 04 дугаар сарын 24-ний 15/01110/20 дугаар техникийн нөхцөл
2.	Зураг төсөл боловсруулах үе шат хугацаа	<ul style="list-style-type: none">- Бэлтгэл ажил (инженер геологийн дүгнэлт, дэвсгэр зургийн тодруулга)- Цахилгаан хангамжийн шугам сүлжээний иж бүрэн ажлын зураг төсөл
3.	Байршил, газар эдэлбэрийн одоогийн байдал	<ul style="list-style-type: none">- Налайх дүүргийн 1 дүгээр хороо, Баянзүрхийн 6-16 дугаар гудамжны 201 нэгж талбарын 235 өрх
4.	Ажлын зураг төсөл боловсруулахад ашиглах материал	<p>Монгол Улсын хуулиуд:</p> <ul style="list-style-type: none">- Газрын тухай болон Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль;- Хот байгуулалтын тухай хууль;- Барилгын тухай Монгол Улсын хууль;- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;- Эрчим хүчний тухай хууль;- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль;

		<ul style="list-style-type: none"> - Хот суурин газрыг дахин хөгжүүлэх хууль; - Бусад холбогдох хууль тогтоомжууд <p>Төсөл, хөтөлбөрүүд:</p> <ul style="list-style-type: none"> - Улаанбаатар хотын бүсийн хөгжлийн хөтөлбөр; - Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотголын баримт бичиг; - Бусад холбогдох төслүүд <p>Норм, нормативууд:</p> <ul style="list-style-type: none"> - Цахилгаан байгууламжийн зураг төсөл, угсралтын дүрэм” БД 43.101.03 - Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилт БНБД 30-01-04 - Барилгад хэрэглэгдэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт БНБД 23.01.09/ - Орон сууц, олон нийтийн барилгын цахилгаан тоног төхөөрөмжийг угсрах ба төлөвлөх /БНБД 43.102.07/ - 0,4-22 кВ-ын хүчдэлийн хуваарилах шугам сүлжээний дэд өртөө барьж байгуулахад тавигдах шаардлага - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм - Барилга байгууламжийн галын аюулгүйн байдал БНБД 21.01.02 - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНБД 21.02.02 - Захиалагчийн дүрэм УББ12-201-01 - Барилгын орчны тохижилтын ажил БНБД 3.01.06-90 - Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт тавих дүрэм БНБД 11-04-99 - Бусад холбогдох норм, дүрэм, стандартуудыг мөрдлөгө болгох <p>Холбогдох журмууд:</p> <ul style="list-style-type: none"> - Монгол улсын Засгийн газрын 2017 оны 3 дугаар сарын 07-ний өдрийн 68 дугаар тогтоолоор баталсан “Барилгын ажлыг эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм” - Монгол улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 317 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм” - Бусад холбогдох журмууд
5.	Төлөвлөлтийн нийт ачаалал	<ul style="list-style-type: none"> - Дулааны ачаалал 2.3 Гкал/цаг бөгөөд цахилгаанаар шийдвэрлэсэн нөхцөлд 940 кВт /Халаалтын ачааллыг хэрэглэгчийн бодит хэмжилттэй уялдуулан нарийвчлан тооцох/
6.	Ажлын зураг төслийн бүрдэл	<ul style="list-style-type: none"> - 110/35/10 кВ-ын “Налайх” дэд станцын 10 кВ-ын Туул фидерийн тулгуур №15-16-ын хооронд салбарлалтын анкер тулгуур босгож, агаарын болон кабель шугам татаж, шинээр баригдах дэд өртөө /ХТП/-ний I секцийг тэжээх ажлын зураг төсөл, - 110/35/10 кВ-ын “Налайх” дэд станцын 10 кВ-ын Зах фидерийн тулгуур №9-ыг салбарлалтын анкер тулгуур болгон сольж, агаарын болон кабель шугам татаж, шинээр баригдах дэд өртөө /ХТП/-ний II секцийг тэжээх ажлын зураг төсөл, <p>Айл өрхийн дулааны ачааллыг цахилгаан халаагуураар халаах холболтын ажлын иж бүрэн зураг төсөл</p>


 ӨРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
 2020 оны 04 -р сарын 24 өдөр
 ТТА4518 - 2117401

		<p>Зураг төсөлд тавигдах шаардлага:</p> <ul style="list-style-type: none"> - Зураг төслийн баримт бичиг 4 хувь. Үүнээс: график зураглал CD-ний хамт 2 хувийг захиалагчид, үндсэн хувийг архивт өгнө. - Инженерийн шугам сүлжээний ажлын зургийг UTM-координатын системд хийж гүйцэтгэн батлагдсан ажлын зургийг CD-ээр Хот байгуулалт, хөгжлийн газрын Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэст хүлээлгэн өгөх. - Ажлын зурагт инженерийн бэлтгэл арга хэмжээ, улаан шугам, шугам сүлжээний одоогийн байдал болон төлөвлөлтийг нэг дэвсгэр зураг дээр нэгтгэн, хоорондын зай хэмжээг огтлолын зургаар тодорхой үзүүлж, норм стандартын дагуу төлөвлөж, шугам сүлжээний ашиглалтын байгууллагуудтай зөвшилцсөн байх шаардлагатай.
7.	Инженерийн хангамжийн байгууламжийн үндсэн хийц	<p>Дэд станц:</p> <ul style="list-style-type: none"> - Төлөвлөлтийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийн чөлөөлсөн талбайд холбогдох норм дүрмийн дагуу байршуулах. - Тухайн хороолол, хотхоныг тэжээж буй дэд станцууд нь ижилхэн, нэг маягийн хийцтэй байх, - Дэд станцын барилгын дотор ханын материал нь тоосго болон түүнтэй дүйцэхүйц шатдаггүй хатуу материалтай байх - Дэд станцын барилга нь гадна талаасаа орчны архитектурт уусч нийцсэн өнгө, үзэмж, засал хийцтэй байх - Дээврийн ус хаалгатай хана талруу урсахааргүй байх - Дэд станцын ханын материал нь шатдаггүй хатуу материалтай байх - Дэд станц, суурилуулсан тоног төхөөрөмжүүд, тэдгээрийн бүтээц нь стандартын шаардлагад нийцсэн байх <p>10 кВ-ын кабель шугам:</p> <ul style="list-style-type: none"> - Ачаалалд тохирсон хөдлөн огтлол бүхий кабель шугам татаж, шинэ дэд станцуудыг тэжээх - Хэрэглэгчийн хэрэглээ, ачаалалтай уялдуулан кабель шугам, трансформаторуудын хүчин чадлыг тооцоогоор сонгох - Кабелиуд 10 кВ-ын хүчдэлийн түвшинд ашиглах, орчны температур -15 хэм байхад угсралт хийх боломжтой байх - Цахилгааны кабель, шугам, тоноглолуудыг орчин үеийн дэвшилтэт техник, технологийн шийдлийг тусгасан, байгаль орчинд ээлтэй байхаар сонгох - Айл өрхийн дулааны ачааллыг цахилгаан халаагуураар халаах холболтыг халаалт, халуун ус, салхивчийн систем тус бүрт зориулан монтажлах боломжтой байх. Үүнд: <ol style="list-style-type: none"> 1. Халаалтын систем: Панелан халаах хэрэгсэл, шалны халаах хэрэгсэл, бага хүчин чадлын цахилгаан халаагуур бүхий усан болон тосон ажлын бие бүхий халаалтын систем гэх мэт 2. Хэрэгцээний халуун усны систем: Эзэлхүүний болон агшин зуурын төхөөрөмж суурилуулах



		3. Салхивч: Хэрэв албадмал салхивчийн агаар оруулах болон сорох систем, рекуператор төхөөрөмж ашиглах
8.	Инженерийн хангамж	<ul style="list-style-type: none"> - Инженерийн бэлтгэл арга хэмжээ: Шинээр хийх болон одоо байгаа далан сувагт ус зайлуулах системийг холбоно. - Дулаан хангамж: Цахилгаан халаалтын системээр хангагдана. - Усан хангамж: Төвлөрсөн усан хангамжийн шугамаас хангагдана. - Ариутгах татуурга: Төвийн бохир усны шугамд холбогдоно. - Авто зам: Хотын болон хорооллын замтай холбоно. - Мэдээлэл холбоо, дохиолол: Холбооны өндөр хурдны сүлжээнд холбохоор төлөвлөнө. - Ногоон байгууламж: Явган зам талбай, нийтийн эзэмшлийн талбайг Барилгын тухай хуулийн 10.1.4 дүгээр заалтыг мөрдөж төлөвлөнө.
9.	Шугам сүлжээний трасс сонголтонд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Авто зам, төмөр зам, инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвасыг тогтоох. - Бусад инженерийн шугам сүлжээний төлөвлөсөн ажлын зурагтай уялдуулах
10.	Эдийн засгийн тооцоо, төсөв	Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНБД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн програмаар тооцно.
11.	Зураг төсөл боловсруулах хугацаа	Гэрээнд заасан хугацаанд
12.	Зураг төсөл боловсруулах байгууллага	Зөвлөх үйлчилгээний 1.2.1, 1.2.5, 1.3.3, ЗТ-3.6, ЗТ-4.6, ЗТ-5.6 ЗТ -6.2, заалттай эрх бүхий хуулийн этгээд
13.	Зураг төслийн санхүүжилт	Нийслэлийн төсөв
14.	Төслийн захиалагч	НЗДТГ, Орон сууцны дэд бүтцийн газар
15.	Галын аюулгүй байдлын нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал БНБД 21.01.02 - Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНБД 21.02.02
16.	Байгаль орчны үнэлгээ нөхцөл	- Шаардлагатай тохиолдолд байгаль орчны үнэлгээ хийлгэх
17.	Онцгой нөхцөл (Төлөвлөлтийн шаардлагаар гарах нэмэлт шаардлагууд трассын дагуух газар чөлөөлөх, хөрсний шинж чанараас хамаарсан	<ul style="list-style-type: none"> - Шугам сүлжээ болон түүнтэй холбогдох барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн ашиглахаар тусгаж өгөх. - Батлагдсан зураг төслийн дагуу барилга угсралтын ажил гүйцэтгэх.

ЕРӨНХИЙ АРХИТЕКТОРЫН АЖЛЫН АЛБА
2020 оны 04-р сарын 24 өдөр


ТТА4518 № 2117401


нэмэлт төлөвлөлт, шинэ техник технологи хэрэглэх гэх мэт)	<ul style="list-style-type: none"> - Батлагдсан хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, барилгажилтын төсөлтэй уялдуулах. - Ажлын зураг төсөлд авто зам, ногоон байгууламж, тохижилтын ажлыг нөхөн сэргээх зардлыг холбогдох дүрэм журам, үнэлгээний дагуу тооцон төсөвт тусгах.
---	--

ХЯНАСАН:


ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА  Ч.БУМ-ЭРДЭНЭ


ЗӨВШӨӨРСӨН:

ОРОН СУУЦНЫ ДЭД БҮТЦИЙН ГАЗРЫН ОРЛОГЧ ДАРГА  Б.АЗЖАРГАЛ

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР, ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  Б.ОЮУНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР, ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ЦАХИЛГААНЫ ИНЖЕНЕР  Д.ТУЛГА

ХОТ БАЙГУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН ГАЗАР, ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТСИЙН ДУЛААНЫ ИНЖЕНЕР  П.ЦЭРЭНЖАРГАЛ



БАТЛАВ
УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨРИЙН
ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Д.БАЯРСАЙХАН

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар 15/01110/20

2020 оны 04 сарын 21 өдөр

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий мэдээлэл:

1.1	Хүсэлтийн дугаар:	20-99-000367
1.2	Хэрэглэгчийн нэр, регистр:	НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ ДЭД БҮТЦИЙН ГАЗАР Төрийн байгууллага - РД: 5673224,
1.3	Хэрэглэгчийн байршил:	Улаанбаатар Налайх 1-р хороо, Баянзүрхийн 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 16 дугаар гудамж
1.4	Ажил үйлчилгээний зориулалт:	Инженерийн байгууламж
1.5	Техникийн нөхцөл олгох үндэслэл:	1) Нийслэлийн Засаг даргын 2020 оны 03 сарын 24- ний өдрийн А/398 дугаар захирамж. 2) Архитектур төлөвлөлтийн 2019 оны 06 сарын 21-ний өдрийн МЗХ2019/11-031 дугаартай даалгавар. 3) Эрчим хүчний яамны 2020 оны 04 сарын 09-ны өдрийн в/1181 тоот албан бичиг. 4) ЦДҮС ТӨХК-ийн 2020 оны 04 сарын 20-ны өдрийн 02/681 тоот албан бичиг.
1.6	Техникийн нөхцөлийн ангилал:	Шинэ холболт
1.7	Тооцооны бүрэн чадал:	940 кВА /Есөн зуун дөч/ (тоогоор) (үсгээр)

Хоёр. Холболтын цэг:

2.1	Дэд өртөөний 10 кВ-ын I секцийг: 110/35/10 кВ-ын Налайх дэд станцын 10 кВ-ын Туул фидерийн тулгуур №15-16 хооронд салбарлалтын анкер тулгуур босгож салбарлалт авах, салбар шугамын эхний тулгуурт хуурай салгуур суурилуулан бүрээстэй агаарын болон кабель шугам татаж шинээр баригдах ХТП-ийн 10 кВ-ын I секцийг тэжээх. Дэд өртөөний 10 кВ-ын II секцийг: 110/35/10 кВ-ын Налайх дэд станцын 10 кВ-ын Зах фидерийн тулгуур №9-ыг салбарлалтын анкер тулгуур болгон сольж салбар шугамын эхний тулгуурт хуурай салгуур суурилуулан бүрээстэй агаарын болон кабель шугам татаж шинээр баригдах ХТП-ийн 10 кВ-ын II секцийг тэжээх.
-----	---

Гурав. Тоолуур, хэмжих хэрэгсэл:

3.1	Дэд өртөөний 0,4 кВ талын ерөнхий оруулгуудад DLMS протоколыг дэмждэг 3 фазын баталгаат, бүрэн электрон тоолуур, гүйдлийн трансформаторыг тусгай хайрцагт суурилуулах.
-----	--

Дөрөв. Тусгай заалтууд:

4.1	Олон улсын стандартын шаардлага хангасан, алдагдал багатай 2*800 кВА чадалтай, 10/0.4 кВ-ын хүчдэлийн, хүчдэл тохируулгын 5 шатлалтай
-----	---

	трансформатор бүхий дэд өртөөг өөрийн эзэмшлийн газарт шинээр барих.
4.2	Шинээр баригдах дэд өртөөний 10 кВ талын хуваарилах хуваарилах байгууламж нь 10-аас доошгүй ячейк суурилуулсан байх.
4.3	УБЦТС ТӨХК-ийн эзэмшлийн шугам дэд станцад хийгдэх өргөтгөлийн ажлыг харьяа түгээх төвөөр гүйцэтгүүлэх.
4.4	10 кВ-ын Туул фидерт 2 талдаа хуурай салгуур бүхий алсын удирдлагатай, УБЦТС ТӨХК-ийн СКАДА системтэй холбогдож ажилладаг реклоузериин пункт суурилуулах. Реклоузериин пункт суурилуулах байршлыг ажлын зураг төслийн шатанд тус компанитай зөвшилцөх. 4.4.1) Шинээр суурилуулсан реклоузериин пунктийг Монгол улсын засгийн газрын 2001 оны 263-р тогтоолын 2.6.3-т заасны дагуу УБЦТС ТӨХК-ийн үндсэн хөрөнгөнд шилжүүлэн өгөх.
4.5	0,4 кВ-ын одоо байгаа цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгууруудыг төмөр бетон тулгуураар солих, СИП утасны хөндлөн огтлолыг 3*70+1*56 болгон хөндлөн огтлолыг нэмэгдүүлэн шинэчлэл солих,
4.6	Техникийн нөхцөлийн дагуу шинээр суурилуулах тоноглолууд, агаарын болон кабель шугам, трансформаторууд нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй, дэвшилтэд техник технологи бүхий байх.
4.7	Дэд станцад суурилуулж буй тоноглолууд нь өмнө нь ашиглагдаж байгаагүй шинэ байх, $\pm 10\%$ -ийн хүчдэлийн хэлбэлзэлд хэвийн ажилладаг байх.

Тав. Дор дурдсан техникийн даалгавар, хууль дүрмийг мөрдөх:






5.1	Шугам, дэд өртөөний "Ажлын зураг төсөл"-ийг тухайн нутаг дэвсгэрийн ерөнхий төлөвлөгөө хариуцсан нэгж болон бусад шаардлагатай байгууллагуудтай зөвшилцөн, мэдээллийн санд оруулсан байх, схем холболт, хүчин чадлыг тус компаниар хянуулах.
5.2	Энэхүү техникийн нөхцөлийн дагуу тавигдах шугам, тоноглолууд нь өмнө ашиглагдаж байгаагүй шинэ байх ба Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн баталсан "Техникийн шаардлагын тодорхойлолт"-ыг хангасан байх шаардлагатай. Техникийн шаардлагын тодорхойлолтыг www.tog.mn хаягаар орж хууль, дүрэм цонхноос үзэх.
5.3	Хүсэлт гаргагч нь хэрэглэх чадалдаа тохируулж чадлын хязгаарлагч, богино залгааны гэмтэл заагч датчикийг суурилуулах. Техникийн тодорхойлолтыг Техникийн бодлого зохицуулалтын хэлтсээс авах.
5.4	Цахилгаан шугам сүлжээнд холбогдох явцад дайрч гарах зам талбай, бут сөөгийг сэргээн засварлах.
5.5	"Эрчим хүчний тухай хууль"-ийн 30.1.13-д заасны дагуу нийтийн эзэмшлийн орон сууцны барилга барьж ашиглалтад оруулсан тохиолдолд барьсан эрчим хүчний дэд станц, шугам, тоноглолыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид шилжүүлэх.
5.6	Засгийн газрын 2001 оны 263 тоот тогтоолоор батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн заалтуудыг мөрдлөг болгох.
5.7	"Эрчим хүчний тухай" хуулийн 29.1.9, 30.1.10-ийн дагуу өөрийн тоноглолоос тус компанийн зөвшөөрлөөр шинээр хэрэглэгч нэмж холбуулах.
5.8	Хэрэглэгч нь техникийн нөхцөлийн дагуу захиалсан чадлаа бүрэн ашиглаж чадаагүй нь цахилгаан эрчим хүчний хэрэглээгээр нотлогдсон бол олгогдсон чадлын хэмжээг бууруулж дахин техникийн нөхцөл олгоно.
5.9	"Эрчим хүчний тухай" хуулийн 33 дугаар зүйлд заасны дагуу шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр, орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

5.10	Дэд өртөө, щитний газардуулга болон шугам тоноглолын хэмжилт, туршилтыг норм, дүрмийн дагуу хийлгэн холбогдох газраар шалгуулж протокол авсан байх.
5.11	Угсралтын ажлын явцад тус компанийн харьяа түгээх төвөөр хяналт тавиулж, холбогдох баримтыг бүрдүүлсэн байх.
5.12	Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй эрх бүхий байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм, Техник ашиглалтын дүрэм, Цахилгаан байгууламжийн дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.
5.13	Цахилгаан эрчим хүчний тооцоог Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ төрийн өмчит хувьцаат компанийн харьяа хэрэглэгчдэд үйлчлэх төвтэй хийх.

Зургаа. Бусад:

6.1	Энэхүү техникийн нөхцөлийн дагуу холболтыг 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна.
-----	--

Комиссын гишүүд:

 Л.Ганзориг
 Б.Аззаяа
 Т.Мөнхболд
 Г.Баттөмөр
 Ш.Бадамцэцэг

Боловсруулсан: